МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

# МОНГОЛЫН БАГШ НАРЫН ҮII ИХ ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭРИЙН МӨРӨӨР БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛУУД

Боловсролын хүрээлэн

**Нэг.**

- Монголын багш нарын VII их хурлаас гарсан “Цөм хөтөлбөрийн агуулга хүнд, цагтаа багтахгүй байна.
- Ахлах ангийн хичээлийн цаг хүрэлцэхгүй байгааг судалж шийдвэрлэх, бага ангид судлах хичээлийн тоог багасгах” гэсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй ажил:

# ЕБ-ын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих суралцахуйн удирдамжийг сайжруулах ажлын явцын танилцуулга

## “ТИМСС/ПИРЛС-2011” ТУРШИЛТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН (БСШУЯ.2010)




## СУРАГЧДЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН (БҮТ. 2018)













## СУРАГЧДЫН СОРИЛЫН ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН (БХ.2019)












# Багш нарын үндэсний хэлэлцүүлгээс гарсан санал

- Агуулга их, цагтаа багтдаггүй. *агуулгын давхцал (1-3.1%) хүндрэл (9%) байгаад тохиргоо хийх*
  - *Бага боловсролын зарим хичээл агуулгын давхардал их*
  - *Суурь боловсролын газарзүй, мэдээллийн технологи, дүрслэх урлаг, 9 дүгээр ангийн химийн агуулга их*
  - *Ахлах ангид хичээл заах багшийг бодлоготойгоор бэлтгэх*
  - *Ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг, дүүргэлтийг судалж оновчтой тогтоох*
  - *Боловсролын салбарын мэргэжлийн удирдлагыг томилох оновчтой шийдлийг олж, боловсролын хуулиар баталгаажуулах*
- Нэг суралцахуйн зорилтод ногдох хугацаа ялгаатай.
  - *Бага боловсролд 2,5-3,3 цаг*
  - *Суурь боловсролд 2,1-2,8 цаг*
  - *Бүрэн дунд боловсролд 1,5-2,7 цаг байна*
- Суралцахуйн зорилт дахь танин мэдэхүйн дээд түвшний үйл
  - *Бага боловсролд 34,1-62,8%*
  - *Суурь боловсролд 32,3-46,3%,*
  - *Бүрэн дунд боловсролд 22,2-48,6%*

# Суурь боловсролын суралцахуйн удирдамжийг сайжруулж буй явц, үр дүн

Суралцахуйн зорилт (өмнөх, сайжруулсан)




Нэг суралцахуйн зорилтыг судлах цаг



# Суурь боловсролын суралцахуйн зорилтын сайжруулалт

| |
|---|
| Өмнөх суралцахуйн зорилтын тоо |
| Одоогийн (сайжруулсан байдлаар) |
| Шинээр нэмсэн суралцахуйн |
| Хассан суралцахуйн зорилтын тоо |
| Шилжүүлэн хассан суралцахуйн |
| Шилжүүлэн нэмсэн суралцахуйн |
| Нэгтгэснээр хасагдсан суралцахуйн |
| Задалснаар нэмэгдсэн суралцахуйн |
| Найруулга зассан суралцахуйн |
| Өөрчлөгдөөгүй суралцахуйн |
| Агуулгад тохиргоо хийсэн (хувиар) |
| Агуулгад орсон өөрчлөлт (хувиар) |
| Сургалтын төлөвлөгөөн дахь судлах |
| Нэг суралцахуйн зорилтыг судлах |






# СӨБ-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зөвлөмж боловсруулах ажлын явцын танилцуулга

БХ-ээс Үндэсний багийн материалд шинжилгээ хийхэд СӨБ-ын хүрээнд шийдвэрлэх асуудлууд дараах 3 чиглэлд багцлагдаж байсан болно.

1. Бодлогын хүрээнд хийгдэх ажлууд (Хөтөлбөр, стандарт боловсруулах, дүрэм журам гаргах гэх мэт 23 санал/зөвлөмж)

2. Хөтөлбөрийг сайжруулах, тодруулахтай холбогдсон ажлууд (Агуулгыг тодорхой болгох, насаар ангилж өгөх гэх мэт 29 санал/зөвлөмж)

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зохион байгуулалтын ажлууд (Үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, ном гарын авлага, зөвлөмжийг боловсруулах гэх мэт 19 санал/зөвлөмж)

1. Цөм хөтөлбөрт “Хүүхдийн жишиг үйл” нийтлэг байсныг багш нар тухайн насны хүүхэдтэй ажиллахдаа хэрэглэхэд боломжтойгоор түвшинчлэн тодорхой болгож байна
2. Цэцэрлэгт явагдах өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй, багшид ачаалал багатай явуулах арга зүйн санаануудыг тусгаж байна (Төлөвлөлт, цэцэрлэгийн хөтөлбөрийн хөгжил, хүүхдийн үнэлгээний хялбаршуулалт гэх мэт)
3. Хүүхдийн нягтрал ихтэй бүсэд цэцэрлэг барих судалгааг оновчтой хийх
4. 50-иас дээш хүүхэдтэй цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах асуудлыг судлах (багшийн норм 7 хоногийн 40 цаг. 2 ээлжийн багш 6 цаг хүүхэдтэй ажиллаад, 2 цаг хичээлийн бэлтгэл хангах, ажил эхлэх цаг 7:00-13:00, 11:00-19:00)

# Тусгай чадварын түвшин бүрийн “Хүүхдийн жишиг үйл”-ийн боловсруулалт (математик)

<table>
<tr><th>Чадвар</th><th>I түвшин</th><th>II түвшин</th><th>III түвшин</th></tr>
<tr><td rowspan="3">1.Тоолох, тоо бодох</td><td>Нэг ба олныг ялгана.</td><td>Тоолно, тоогоор нь харьцуулна, нэмэгдүүлнэ, хорогдуулна, дэс тоо хэрэглэнэ.</td><td>Тооны цифр, тэмдэг тэмдэглэгээ хэрэглэнэ, хялбар бодлого зохионо, бодно.</td></tr>
<tr><th colspan="3">Хүүхдийн жишиг үйл</th></tr>
<tr><td colspan="3">✓ Орчны зүйлсээс олон ба цөөнийг ялгаж хэлнэ. (Жишээнь: Манай ангийн ширээ цөөн, сандал олон)<br>✓ Хэд байна вэ? Хичнээн? гэсэн асуултад хариулна.<br>✓ Цээжээр болон 10 хүртэл оноож тоолно.<br>✓ Тоглохдоо дэс тоо хэрэглэнэ. (Жишээ нь: Би эхлээд, хоёрдугаарт Мөнхөө, гуравдугаарт Жаргалмаа...)<br>✓ Хэмжээ, өнгөөрөө ялгаатай, ижил тоотой дүрсүүдийг янз бүрийн байрлалд байрлуулж тоолох дасгал ажиллана.<br>✓ Багштайгаа хамтран сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэнэ. (Жишээ нь: Янз бүрийн тооны эд зүйлстэй картууд, сургах тоглоомын материал, зурагт хуудас, цифр)<br>✓ Тоолоод дүн тоог олон хувилбараар илэрхийлнэ. (Жишээ нь: Нэрлэх, хуруугаараа, цифрээр, зургаар)<br>✓ Төрсөн өдөр, гэрийнхээ хаалганы дугаарыг хэлнэ, утсанд дуудлага хийнэ.<br>✓ Юмсыг тоогоор нь харьцуулж, тэнцүү ба тэнцүү бишийг олно.<br>✓ Эд зүйлс, тоглоом наадгайг нэгээр хорогдуулна, нэмэгдүүлнэ.<br>✓ Юмсыг тоолоод тохирох цифртэй холбоно.<br>✓ Тоог хоёр буюу хэд хэдэн бага тоо болгон задлах дасгал хийнэ. (Жишээ нь: 5-ийг 1,1,1,1,1 мөн 4+1, 3+2 болгон задлах)<br>✓ 10-ын дотор нэмэх, хасах сонирхолтой бодлого зохионо, бодно.<br>✓ “Алаг мэлхий”, “Шагай түүх, шүүрэх”, “Чулуу таалцах”, “Морь уралдуулах” гэх мэт ардын тоглоомоор тоглоно.</td></tr>
</table>

# Тусгай чадварын түвшин бүрийн “Хүүхдийн жишиг үйл-ийн боловсруулалт (**Математик**)

| **Агуулгын хүрээ** | **Чадвар** | | |
|---|---|---|---|
| | **I түвшин** | **II түвшин** | **III түвшин** |
| **1.Тоолох, тоо бодох** | Нэг ба олныг ялгах | Тоолох, тоогоор нь харьцуулах, нэмэгдүүлэх, хорогдуулах, дэс тоо хэрэглэх | Тооны цифр, тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх, хялбар бодлого зохиох, бодох |
| | **Хүүхдийн жишиг үйл** | | |
| | • Нэг эд зүйл, хүн, амьтныг заагаад “Хэдэн ... байна вэ?” гэж асуухад хариулна.<br>• “Багшдаа олон тоглоом (бөмбөг, машин гэх мэт), эд зүйл (хандаа, халбага гэх мэт) аваад ир дээ?” гэхэд олныг авч ирнэ.<br>• Нэг нэг бөмбөгийг нийлүүлж, олон болгоно.<br>• Олон хүний зураг харуулаад “Олон хүн байна уу, цөөн хүн байна уу?” гэж асуухад тохирох хариулт өгнө.<br>• Орчиндоо байгаа зүйлээс олон ба нэг юмыг олж харж хэлнэ. (Жишээ нь: манай ангид хүүхэлдэй олон, бамбарууш нэг байна.)<br>• 1-3 тоглоомыг тоолоод дүн тоог олон хувилбараар илэрхийлнэ. (Жишээ нь: нэрлэх, хуруугаараа, зургаар харуулах) | • 10 хүртэл эд зүйлийг оноож тоолоод, дүн тоог хэлнэ. (шагай, савх, бөглөө, дүрс, зурган карт, тоглоом, чулуу, цэцэг гэх мэт.)<br>• Тодорхой тооны эд зүйлээс нэг нэгээр хорогдуулж, үлдсэнийг нь тоолж хэд болсныг хэлнэ.<br>• 10-ын дотор эд зүйл, хүн, амьтны зургийг нэг нэгээр нэмэгдүүлж тоолоод, хэд болсныг хэлнэ.<br>• Хоёр бүлэг зүйлсийг тоолж, харьцуулна, аль нь олон байгааг хэлнэ. (Жишээ нь: Тавиурын дээд талд 5 машин, доод талд 3 машин)<br>• 10-ын доторх эд зүйл, хүн, амьтны зургийг тоолоод тэнцүү биш байгаа тохиолдолд нэмэгдүүлэх буюу хорогдуулах замаар тэнцүү болгоно.<br>• Тоог хоёр буюу хэд хэдэн бага тоо болгон задлах дасгал хийнэ. (Жишээ нь: 5-ийг 1,1,1,1,1 мөн 4+1, 3+2 болгон задлах)<br>• Тоглохдоо дэс тоо хэрэглэнэ. (Жишээ нь: Би эхлээд, хоёрдугаарт Мөнхөө, гуравдугаарт Жаргалмаа) | • Савх, шүдэнзний мод, баримлын шавраар, нэмэх, хасах тэмдэг, цифрийг дүрслэн тоглоно.<br>• 0-10-ын цифрийг нэрлээд, дэс дараалын дагуу байрлуулна.<br>• 10-ын доторх тооны дүрс, эд зүйлс, амьтны зургийг тоолоод, тохирох цифртэй холбоно.<br>• Анги, цэцэрлэгт байгаа тэмдэг тэмдэглэгээ (ангийн дүрэм, 00-ын тэмдэглэгээ, шатны дүрэм гэх мэт)-г тайлбарлаж ярина.<br>• Эд зүйлс, дүрс, зургийг тоолоод тохирох цифрээр тэмдэглэнэ.<br>• Багштайгаа хамтран сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэнэ. (Жишээ нь: Янз бүрийн тооны эд зүйлстэй картууд, сургах тоглоомын материал, цифр)<br>• Төрсөн өдөр, гэрийнхээ хаалганы дугаарыг хэлнэ, цифрээр харуулна, утсанд дуудлага хийнэ.<br>• Үндсэн ба дэс тоог ялгаж хэд вэ?, хэддүгээрт вэ? гэсэн асуултад хариулна.<br>• 1 ба 2-оор нэмэгдүүлэх буюу хорогдуулах сонирхолтой бодлого зохиож, бусад хүүхдээр бодуулна.<br>• “Алаг мэлхий”, “Шагай түүх, шүүрэх”, “Чулуу таалцах”, “Морь уралдуулах”, “Хорол” гэх мэт ардын тоглоомоор тоглоно. |

**Хоёр**.

- Монголын багш нарын VII их хурлаас гарсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг тогтвортой мөрдөх хууль эрх зүйн орчныг бий болгох”,

- “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээ, сурах бичгийг мэргэжлийн түвшинд үнэлж, хөгжүүлдэг байхаар нөхцөл, шаардлагыг боловсруулах” гэсэн асуудлуудын хүрээнд хэрэгжүүлж буй ажил:

# Сургалтын цөм хөтөлбөрийн боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх хөтөлбөрийн менежментийн цикл







*2018 оны 08 дугаар сарын 30-ны А/549 дугаар тушаал*

# Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх, дахин сайжруулах



Анхааран сонссон танд баярлалаа